

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

“БАЯН-ӨЛГИЙ ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА Ж.КЕРЕЙ ТАНАА

2023.03.15 № 325
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 508 тоот тогтоолоор цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, борлуулах зарим цахилгааны чадлын тарифыг нэмсэн байна.

Аудитын гол асуудал

Хятад улсад сэлбэг, бараа материал худалдан авахад 147.3 сая төгрөг шилжүүлж авлагаар тайлагнасан, худалдан авах босго үнийн дээд хязгаарыг зөрчиж 187.8 сая төгрөгийн сэлбэг, бараа материалыг шууд гэрээгээр болон гэрээгүйгээр худалдан авсан асуудлыг анхаарах шаардлагатай.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	Төгрөгөөр 2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	715,474,512.25	417,504,462.74
1.1.2	Дансны авлага	547,058,486.07	1,747,780,787.09
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	208,363,412.85	66,293,592.19
1.1.4	Бусад авлага	623,448,592.00	183,829,473.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	233,485,273.10	196,137,321.10
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,327,830,276.27	2,611,545,636.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,094,289,902.61	7,430,411,151.81
1.2.2	Биет бус хөрөнгө	130,476,800.00	130,476,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,224,766,702.61	7,560,887,951.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,552,596,978.88	10,172,433,587.93
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	79,533,139.52	157,457,160.05
2.1.1.3	Татварын өр		468,640.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	79,533,139.52	157,925,800.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,216,120,876.22	2,294,513,536.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	10,698,433,754.84	10,698,433,754.84
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	480,277,808.77	480,277,808.77
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	927,172,584.91	1,178,201,908.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,769,408,045.86)	(4,478,993,420.43)
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,336,476,102.66	7,877,920,051.18
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	10,552,596,978.88	10,172,433,587.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	Төгрөгөөр 2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,489,796,933.51	12,091,486,724.60
2	Борлуулалтын өртөг	7,444,207,731.60	8,493,516,747.00
3	Нийт ашиг(алдагдал)	3,045,589,201.91	3,597,969,977.60
5	Хүүний орлого	6,945,853.30	41,772,496.92
8	Бусад орлого	60,055,459.56	110,882,759.81
9	Борлуулалт, маркетингийн зардал	24,786,929.24	20,937,600.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,652,007,327.06	195,840,776.47
11	Санхүүгийн зардал	1,437,870,542.74	3,306,427,872.60
12	Бусад зардал	27,327,473.78	932,594,346.23
17	Бусад ашиг (алдагдал)	(186,340,052.99)	

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(215,741,811.04)	(705,175,360.97)
19	Орлогын татварын зардал	694,585.33	4,177,249.69
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(216,436,396.37)	(709,352,610.66)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(216,436,396.37)	(709,352,610.66)
24	Орлогын нийт дүн	(216,436,396.37)	(709,352,610.66)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Төгрөгөөр	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	927,172,584.91	(3,769,408,045.86)	8,336,476,102.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				250,796,559.18	250,796,559.18
Залруулсан үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	927,172,584.91	(3,518,611,486.68)	8,587,272,661.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(709,352,610.66)	(709,352,610.66)
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	927,172,584.91	(4,227,964,097.34)	7,877,920,051.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Төгрөгөөр	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,538,403,828.08	12,091,485,924.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,363,530,785.32	8,764,481,582.25
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	47,574,226.19	
	Татаас, санхүүжилтийн орлого	5,874,287,033.26	2,596,875,954.58
	Бусад мөнгөн орлого	253,011,783.31	730,128,387.73
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,562,209,149.61	5,429,455,974.07
	Ажиллагчдад төлсөн	1,144,867,411.00	1,291,255,400.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	382,218,821.73	413,354,089.63
	Бараа материал худалданавахад төлсөн	423,851,293.00	439,752,968.00
	Ашиглалтын зардалд төлсөн	10,015,482.00	5,174,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	229,781,898.00	406,793,444.10
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	602,716,814.63	294,174,196.37
	Даатгалын төлбөрт төлсөн	24,754,692.43	11,508,078.00
	Бусад мөнгөн зарлага	744,002,736.82	2,567,443,797.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,976,194,678.47	6,662,029,950.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,721,000,000.00	6,960,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	5,721,000,000.00	6,960,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн	(5,721,000,000.00)	(6,960,000,000.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	255,194,678.47	(297,970,049.51)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	556,622,528.11	715,474,512.25
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	460,279,833.78	417,504,462.74

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төгрөгөөр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Зөрүү	Хувь
				Төлөв-лөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт		10,489,796,933.51	12,345,140,300.00	11,514,012,793.00	(831,127,507.00)	93.3
	Үйлдвэрлэлийн байгууллага	сая.төг	2,140,200,000.00	2,839,600,000.00	2,632,011,000.00	(207,589,000.00)	70.0
	Худалдаа үйчилгээний байгууллага	сая.төг	1,272,600,000.00	1,706,800,000.00	1,020,905,000.00	(685,895,000.00)	99.6
	Төсөвт байгууллага	сая.төг	2,150,000,000.00	920,000,000.00	880,200,000.00	(39,800,000.00)	103.8
	Орон сууц	сая.төг	592,900,000.00	585,450,000.00	617,100,000.00	31,650,000.00	106.4
	Гэр хороолол	сая.төг	1,902,600,000.00	3,861,789,580.00	3,932,296,073.00	70,506,493.00	100.1
	Сумдууд	сая.төг	2,431,496,933.51	2,431,500,720.00	2,431,500,720.00	0.00	98.3
2	Нийт орлого		10,556,798,246.37	12,508,276,000.00	11,514,012,793.00	(994,263,207.00)	90.6
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	10,489,796,933.51	12,292,356,200.00	11,361,357,536.00	(976,359,400.00)	90.4
	Хүүгийн орлого	сая.төг	6,945,853.30	84,418,600.00	41,772,497.00	24,948.53	100.1
	Бусад орлого	сая.төг	60,055,459.56	131,501,200.00	110,882,760.00	5,991,090.85	113.0
3	Нийт зардал		10,773,234,642.74	12,345,140,300.00	12,223,365,403.60	(121,774,896.40)	90.3
	Үүнээс:					0.00	
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	7,444,207,731.60	7,956,270,600.00	8,493,516,747.00	537,246,147.00	92.0
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	1,652,007,327.06	1,650,550,000.00	1,695,840,776.00	45,290,776.00	102.4
	в) Хөрөнгө оруулалт их засвар	сая.төг	187,202,700.00	285,972,000.00	196,931,800.00	(89,040,200.00)	15.5
	г) элэгдлийн зардал	сая.төг	876,015,100.00	953,058,200.00	996,312,556.00	43,254,356.00	107.8
	д) Орлогын албан татвараас бусад татвар	сая.төг	34,479,400.00	5,976,900.00	5,929,200.00	(47,700.00)	130.3
	е) Үйл ажиллагааны зардал	сая.төг	579,322,384.08	1,493,312,600.00	834,834,324.60	(658,478,275.40)	74.1
4	Цэвэр ашиг, алдагдал		(216,436,396.37)	163,135,700.00	(709,352,610.60)	-872,488,310.60	0.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зорилго нь дэвшилтэд технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай түгээн хангаж, хэрэглэгчдээ дээдлэн ажиллахад оршино.

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд

- Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах, тогтвортой хөгжил, аюулгүй, найдвартай ажиллагааг, үр ашигтай байдлыг хангах
- Байгууллагын ажиллагсдын үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангах, урамшуулах, ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажлын байрны нөхцлийг бүрдүүлэх
- Байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг хангахад цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг эзэмшүүлэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ нь анх Баян-Өлгий аймгийн төвд 1951 онд “ДТ-54” маягийн дизель станц суурилуулснаар эрчим хүчний үйлдвэрийн суурь тавигдсан байна. Улмаар 1952-165 онуудад дизель станцаар, 1965-1982 онуудад Чехославак улсын техник, эдийн засгийн тусламжаар баригдсан 3 мВт-ын хүчин чадалтай Дизелийн цахилгаан станцаар хэрэглэгчдийг цахилгаанаар хангаж байсан байна. Баян-Өлгий аймаг 1997 онд Баруун бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор аймаг болон сумууд байнгын эрчим хүчтэй болсон байна.

Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 1999 оны шийдвэрээр “Эрчим” ХК-ийн бүтцийг өөрчилж цахилгаан түгээх, цахилгаанаар хангах үүрэг бүхий Цахилгаан шугам сүлжээний газар нэртэйгээр байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрыг төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд шилжүүлэн, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болсон байна.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5-д “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна” гэж заажээ.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

хуулийн холбогдох заалттай нийцэж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 101 тоот тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэйгээр шинэчлэн тогтоосон байна.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 21.0 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд хийгдсэн арга хэмжээ байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 508 тоот тогтоолоор цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, борлуулах зарим цахилгааны чадлын тарифыг өөрчилсөн байна.

Тус аудитын газраас 2022 онд ҮАГ-ын нэгдсэн удирамжаар тус компанийн үйл ажиллагааны үр ашиг сэдэвт аудитаар 2018-2021 оныг хамруулан гүйцэтгэлийн аудит хийгдсэн байна. Аудитын дүнгээр 66.2 сая төгрөгийн акт тогтоож, ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 129 тогтоол, 2021 оны 124 тогтоолоор баталсан журмыг зөрчиж, шууд худалдан авах босго үнийн өртгийн дээд хязгаарыг зөрчсөн 516.7 сая, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нийтдээ 4,794.1 сая бүгд 5310,8 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна. Албан шаардлагын биелэлтийг ирүүлж, 46.2 сая төгрөгийн актыг барагдуулсан байна.

ЦШСГ-ын дотоод аудитаас хийсэн ажлын тайлан ирүүлсэн ба УЗ-өөс ажлыг үнэлсэн ямар нэгэн нотлох баримт байхгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг “Тунгалаг бүртгэл аудит” ХХК-аар 2020 онд хийлгэж, мөрдөж ажиллаж ирсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 380.2 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		715,474.51	417,504.46	(297,970.05)
Авлага		1,378,870.49	1,997,903.85	619,033.36
Урьдчилгаа		-	-	-
Бараа материал		233,485.27	196,137.32	(37,347.95)
Үндсэн хөрөнгө		8,224,766.70	7,560,887.95	(663,878.75)
Нийт хөрөнгө		10,552,596.98	10,172,433.59	(380,163.39)
Богино хугацаат өглөг		79,533.14	157,925.80	78,392.66
Урт хугацаат өглөг		2,136,587.74	2,136,587.74	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		8,336,476.10	7,877,920.05	(458,556.05)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		10,552,596.98	10,172,433.59	(380,163.39)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 417.5 сая төгрөг болж 297.9 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс кассын үлдэгдэл 0.04 сая, 417.5 сая төгрөгийн арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 1,997.9 сая төгрөгөөр болж 619.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс аж ахуйн нэгж, байгууллагын авах авлага 962.4 сая, айл өрхөөс авах авлага 288.4 сая төгрөгөөр бүгд 1,250.8 сая төгрөгөөр өссөн, бусад байгууллагаас авах авлага 631.8 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь Алтай сумын 0.4кВт-ын шугамын шинэчлэл хийгдэж дуусаагүй тул 157.8 сая төгрөгийн авлагатай. Алтай таван богд, Хилийн цэргийн заставын тендерийн ажил 3 жилийн хугацаатай тул зураг төсвийн урьдчилгаа 30.0 сая, Хятадаас бараа материал захиалсан 88.8 сая, тендерийн гүйцэтгэлийн баталгаа 90.0 сая төгрөгийн авлагатай гарсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 196.1 сая төгрөг болж 37.3 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалттай холбоотой байна.

Тайлант онд 830.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 867.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 196.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 663.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 14.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон аймгийн ОНХСангаас хэрэгжсэн тхөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнгээр э 318.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 157.9 сая төгрөг болж 78.4 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг өссөнтэй холбоотой байна.

“Мэйжүрмэнт” ХХК-д 44.7 сая, “Ховд түгээх сүлжээ” ХХК-д 8.9 сая, “Проект Ватт” ХХК-д 44.1 сая, ГХБХБГ-т 4.0 сая, ХХОАТ-т 0.5 сая, Үйлдвэрчний эвлэлийн татварт 1.9 сая төгрөгийн өглөг нэмэгдэж, ББЭХС ТӨХК-нд төлөх өглөг 23.1 сая, МҮОНРТ-д өгөх өглөг 1.3 сая, бусад өглөг 1.2 сая төгрөг буурсантай байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. ЦШСГ нь 2,136.6 сая төгрөгийн төслийн нь урт хугацаат өр төлбөртэй бөгөөд ямар нэгэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, хөрөнгө оруулалтын их засвар, элэгдлийн зардал, орлогын албан татвараас бусад татвар, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Зардлыг өмнөх онтой харьцуулахад нийт зардал 1450.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, тээвэр шатахуун, сэлбэг хэрэгсэл, бусад зардлууд байна.

Тайлант онд 193.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ”,

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

21.10-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аудитын дүгнэлт гарснаас хойш долоо хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

Цахилгаан шугам сүлжээний газар нь хуулийн дээрх заалтын дагуу үйлдвэрийн газрын хүрэх зорилт, түүнийг хэрэгжүүлэх саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж, хянуулж, батлуулж ажилласан байна. Мөн Удирдах зөвлөлийн 2022 оны 02 тоот тогтоолоор 2022 оны бизнес санхүүгийн төлөвлөгөөг батлуулсан байна.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 2022 оны 01 тоот тогтоолоор 2021 оны үйл ажиллагааг үнэлж, удирдах зөвлөлийн гишүүдийн цалин тогтоох, ажилчдын цалин нэмэгдүүлэх болон жилийн үр дүнгийн шагналыг 2.5 сараар бодож олгохоор баталсан байна

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2022 оны нийт орлогыг 12,345.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,345.1 сая төгрөгөөр, 163.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 285.9 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 11,514.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12,223.4 сая төгрөгийн зардал гарган, 709.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гүйцэтгэлээр нийтдээ 11,514.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 90.6 хувиар биелэгдсэн байна.

Борлуулалтын орлого өмнөх 1,024.2 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн нь өмнөх оноос цахилгаан борлуулалтын тариф нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 295.1 сая төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос цалин хөлс, сэлбэг хэрэгсэл, албан томилолт, тээвэр шатахууны зардал, гадны үйлчилгээний хөлс зэрэг зардлууд өссөн байна.

Удирдлагын зардлын төсөвт 190.0 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 195.8 сая төгрөг зарцуулж 5.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Үүнд:

Шатахуун, албан томилолт, харилцаа холбоо, засвар үйлчилгээ, хөдөлмөр хамгаалалын болон үйл ажиллагааны бусад зардлуудыг 0.5-3.0 сая төгрөгөөр хэмнэж, цалин, НДШимтгэл, тээврийн зардал, бичиг хэрэг зардлууд 0.1-10.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Цалин, НДШ-ийг 13.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь цалинг 15 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалт их засварын 45 төсөл арга хэмжээнд бүгд 1,300.2 сая төгрөг батлагдсанаас 24 төсөл арга хэмжээнд 414.8 сая төгрөг зарцуулж 15 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлуудыг бууруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг “Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 10,556.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 211.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 168.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор арга хэмжээ ажиллаагүй дараах зөрчил гарсан байна. Үүнд:

1. Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 7878.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан байна.

Тоёто Ланд-105, Тоёто Такома, Тоёто Пробокс, Приус-20, Фургон -39099 зэрэг 5 авто машин байгаа ба 3 нь хот дотор засвар үйлчилгээнд, 2 нь хөдөө дуудлагад үйлчилгээнд явдаг байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

“Цахилгаан шугам сүлжээ” ОНӨУҮГ нь 2022 онд нийт 10,435.2 сая төгрөгийн 152 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн байршуулсан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 3,594.9 сая төгрөгийн 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд албан шаардлага өгөгдсөн. Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад өмнөх зөрчлийг давтан гараагүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	3,594,900.0	1	3,594,900.0	100.0
Зөвлөмж					
Нийт дүн	1	3,594,900.0	1	3,594,900.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар эрсдэлтэй гэж сонгосон ажил гүйлгээ, дансуудад түүврийн аргаар горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд цаг хугааны хязгаарлагдмал байдлаас шалгаалж бүх ажил гүйлгээ, дансыг шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагай болно. Дараагийн аудитаар энэхүү аудитаар илэрсэн алдаа зөрчлүүд давтгдан гаргасан эсэхийг шалгаж, анхаарал хандуулах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийтдээ 1,665.5 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад холбогдох санхүүгийн тайлангуудад тус тус залруулга хийсэн. Үүнд:

- ✓ Арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдлийг 0.08 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
- ✓ Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдолыг 9.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулсан.
- ✓ Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр ажиллаж олсон нийт 108.6 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнаагүй орхигдуулсныг залруулсан.
- ✓ Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2022 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр ажиллаж олсон нийт 536.8 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнаагүй орхигдуулсныг залруулсан.
- ✓ Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 1,078.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулсан.

Аудитын дүнгээр нийтдээ 330.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 330.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, авлага, өглөгийг барагдуулах талаар 1 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчлүүдэд албан шаардлага өгсөн. Үүнд:

1. Тус аудитын газраас Цахилгаан шугам сүлжээний газрын үйл ажиллагаанд 2022 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 66.1 сая төгрөгийн зөрчлийг газрын дарга, ерөнхий нягтлан бодогч нараар хариуцуулан нөхөн төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоосон бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 46.1 сая төгрөгийг байгууллагын данснаас төлж барагдуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, зардалд бичсэн байна.

2. Бараа материал /ухаалаг тоолуур/, сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа шууд худалдан авах босго үнийн өртгийн дээд хязгаарыг зөрчиж нийт 187,8 сая төгрөгийн сэлбэг, бараа материалыг шууд гэрээгээр болон гэрээгүйгээр худалдан авсан.

3. Хятад улсаас сэлбэг, материал худалдан авах зорилгоор 2022 оны 9 дүгээр сард 58.7 сая төгрөг, 12 дугаар сард 30.1 сая төгрөг бүгд 88.8 сая төгрөгийг бичгээр байгуулсан ямар нэг гэрээгүй, бүрдэл дутуу баримтаар шилжүүлж, авлагаар тайлагнасан боловч одоо хүртэл биетээр хүлээж аваагүй байна.

4. Шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 7.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.
Үүнд:

1. Компанийн урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ЦШСГ нь 2,136.6 сая төгрөгийн төслийн урт хугацаат зээлийн үлдэгдэл бөгөөд төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн байна. Мөн авлага оны эцэст 1,997.9 сая төгрөг болж оны эхнээс 619.0 сая төгрөгөөр, богино хугацаат өглөг 157.9 сая төгрөг болж 78.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Компанийн орлогыг нэмэгдүүлэх, авлагыг барагдуулах, үр ашиггүй зардлуудыг бууруулах замаар урт хугацаат зээлийн төлбөрийг барагдуулахад анхаарах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Арилжааны харилцах дансны үлдэгдэл зөрүүтэй	1	0.8			1	0.8	1	0.8				
Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдолыг дутуу тайлагнасан	1	9258.8			1	9258.8	1	9258.8				
ОНХО-ын санхүүжилтийг борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан	1	108,622.5			1	108,622.5	1	108,622.5				
УТХО-ын санхүүжилтийг борлуулалтын орлогод дутуу тайлагнасан	1	468,850.6			1	468,850.6	1	468,850.6				
Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг дутуу тайлагнасан	1	1,078,817.6			1	1,078,817.6	1	1,078,817.6				
Дүн	5	1,665,550.3			5	1,665,550.3	5	1,665,550.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын

“Баян-өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

									албан шаардлага		байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайланд авлагаар тусгаагүй	1	46,165.3			1	46,165.3						
Бүрдэл дутуу баримтаар бараа худалдан авсан	1	88,809.0			1	88,809.0						
Бараа материал, сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа худалдан авах босго үнийн дээд хязгаарыг зөрчиж худалдан авалт хийсэн	1	187,809.0			1	187,809.0						
Авлагыг барагдуулах, үр ашиггүй зардлуудыг бууруулах замаар урт хугацаат зээлийн төлбөрийг барагдуулах	1	0.0					1	0.0				
Дүн	4	322,783.3			3	322,783.3	1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шагнал, хүлээн авалтад хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан	1	7,878.3			1	7,878.3		
Дүн	1	7,878,3			1	7,878,3		
Нийт дүн	1	7,878,3			1	7,878,3		